



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 113

Хажуу шинэ ус

Г Эцэг эхийн зөвлөл байгуулах тухай Т

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.1 дэхь заалт, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ний өдрийн 03 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Засаг даргын Тамгын газрын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийг 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2 жилийн хугацаатай дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Зөвлөлийн дарга Э.Сувдмаа (Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга Б.Буяннэмэх (Улсын бүртгэгч)

Гишүүдэд А.Бямбадорж (Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч)
Д.Мандахцацрал (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

Н.Ганбат (Нягтлан бодогч)

2. Байгууллага, аж ахуй нэгжийн дэргэд эцэг эхийн зөвлөл байгуулж ажиллуулах зөвлөмжийг үйл ажиллагаандaa чиглэл болгон байгууллагын хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллахыг зөвлөлийн бүрэлдэхүүнд даалгасугай.

3. Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагч нарын хүүхдийн дунд зохион байгуулж, хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хагас бүтэн жилээр хамт олонд тайлагнаж ажиллахыг зөвлөл (Э.Сувдмаа)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн A/10 шийдвэрийг хүчингүйд тооцсугай.

ДАРГА

Н.ӨЛЗИЙТОГОХ